

ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо : 2020 оны 04 дүгээр сарын 03-ны өдөр

Тендер шалгаруулалтын нэр: **Барилгын материал (2 багц) нийлүүлэх**

Тендер шалгаруулалтын дугаар: МРЦМ/202012288

“МОНГОЛПРОСЦВЕТМЕТ” ТӨҮГ-ЫН ХАРЪЯА БОР-ӨНДӨР УБҮ эрх бүхий тендерт оролцогчдоос **БАРИЛГЫН МАТЕРИАЛ (2 БАГЦ)** нийлүүлэх тухай битүүмжилсэн тендер ирүүлэхийг урьж байна.

Тендерийн баримт бичгийг эргэж төлөгдөхгүй нөхцөлтэйгээр иж бүрдэлээр нь **50,000.00 /тавин мянган/** төгрөг, эсхүл түүнтэй тэнцэх хэмжээний чөлөөтэй хөрвөх валютаар худалдан авч болно. Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн **30** хоногийн дотор хүчинтэй байна.

Тендерт оролцогч нь Санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна.

Үүнд:

Борлуулалтын хэмжээ:**Сүүлийн 2 жил буюу 2018, 2019 оны аль нэгд гүйцэтгэсэн борлуулалтын хэмжээ тендерийн үнийн саналын мөнгөн дүнгийн 100%-иас багагүй байна.**

Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ: **Тендерт ирүүлсэн үнийн саналын мөнгөн дүнгийн 50 хувиас багагүй байна.**

Тендерийн хамт:

Багц-1: **2 000 640**

Багц-2: **1 440 000** төгрөгийн дүнтэй тендерийн баталгаа ирүүлнэ.

Тендерийг **2020 оны 05 дугаар сарын 03-ны өдрийн 09:00 цагаас өмнө www.tender.gov.mn хаягаар ирүүлэх ба мөн өдрийн 09:05 цагт цахим системээр нээнэ.**

Гадаадын этгээд тендер ирүүлэх эрхтэй, эрхгүй эсэх: **Зөвшөөрөхгүй.**

Дотоодын давуу эрх тооцох эсэх. **Тооцохгүй.**

Сонирхсон этгээд тендерийн баримт бичигтэй холбоотой болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

**“МОНГОЛПРОСЦВЕТМЕТ” ТӨҮГ-ЫН
ХАРЪЯА БОР-ӨНДӨР УБҮ**